

Томуугийн цартахлын бэлэн байдал (ТЦББ)-ын өмнөх үнэлгээнүүдийн тухай танилцуулга

Академич П.Нямдаваа

- **ТЦББ-ын үнэлгээний хэрэгсэл,
Анхны үнэлгээ (I.A), 2008.IV**
- **Нөхөн үнэлгээ (0 түвшин),
2008.XI**
- **Аймаг, нийслэлийг оруулсан
үнэлгээ (I.B), 2009.III**
- **Хоёрдахь үнэлгээ, 2010.VI**

ТЦББ-ын анхны үнэлгээ

- ТЦББ-ын Монгол улсын үндэсний төлөвлөгөөний үнэлгээг АНУ-ын ӨХТ-д боловсруулсан аргачлалаар Монгол улсын ТҮТ 2008 оны 4 дүгээр сард хийсэн.
- Энэ үнэлгээнд ОБЕГ, ХХААЯ, МЭАЦТЛ, ЭМЯ, ХӨСҮТ, БГХӨҮТ, ЭМХҮТ, ДЭМБ болон НҮБХС-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрууд, АНУ-ын ӨХТ, Энх тайвны корпус, Монголын улаан загалмайн нийгэмлэгийн төлөөлөгчид оролцсон.
- ТЦББ-ын төлөвлөгөөнд үнэлгээ хийх семинарт Шувууны томуу болон хүний томуугийн цартахлын Үндэсний зохицуулах хорооны техникийн ажлын хэсгүүдийн гишүүд мөн оролцсон болно.

ТЦББ-ын үнэлгээний матриц

Үнэлгээ ТЦББ-ын 12 бүлэг асуудлыг хамарсан,
үүнд:

- | | |
|--|--|
| 1. Үндэсний төлөвлөгөө | 8. Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ |
| 2. Судлагаа шинжилгээ, түүний үр дүнг ашиглаж буй байдал | 9. Дэгдэлтийг хязгаарлах нөөц |
| 3. Мэдээлэл, сурталчилгаа | 10. Олон нийтэд тулгуурласан арга хэмжээ |
| 4. Эпидемиологийн чадавхи | 11. Халдвар хамгаалал |
| 5. Лабораторийн чадавхи | 12. Эрүүл мэндийн салбарын бэлэн байдал |
| 6. Томуугийн байнгын тандалт | |
| 7. ТТӨ-ний үндэсний тандалт, мэдээлэл | |

ТЦББ-ын үнэлгээний үзүүлэлт

Бүлэг бүрийн бэлэн байдлыг 0-3 гэж тэмдэглэсэн дөрвөн түвшин болгон үнэлсэн.

CAPABILITY Бүлэг /чадавхи	Level of capability Түвшин			
	Weak Хангалтгүй			Advanced Хангалттай
	0	1	2	3

ТЦББ-ыг үнэлэх семинар

Семинарийг төлөвлөгөөнд үүрэг хүлээсэн бүх талын төлөөлөгчдийг оролцуулан үнэлгээний матрицад орсон асуудал болгоныг нотолгоо баримтад тулгуурлан хэлэлцэх хэлбэрээр зохион байгуулсан.

ЧАДАВХИ 1. Үндэсний төлөвлөгөө - 1

ЧАДАВХИ 1.1.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(А) ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ ЭСЭХ	Гүйцэд боловсруулсан төлөвлөгөө байхгүй	ДЭМБ-ын шалгуурт дурьдсан бэлэн байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай хамгийн наад захын элементүүдийг төлөвлөгөөний төсөлд тусгасан.	Төлөвлөгөөг засгийн газрын түвшинд авч хэлэлцсэн.	Төлөвлөгөөг үндэсний хэмжээнд авч хэлэлцэж, үзүүлэх сургууль болон цаг үеийн яаралтай нохцол байдалтай уялдуулан байнга шинэчилж байдаг.

Академич П.Нямдаваа, ТҮТ

7

ЧАДАВХИ 1. Үндэсний төлөвлөгөө - 2

ЧАДАВХИ 1.2.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(В) ТӨЛӨВЛӨГӨӨГ ТАРААЖ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙДАЛ	Төлөвлөгөөг өргөн цар хүрээтэйгээр тараагаагүй эсвэл төлөвлөгөө олон нийтэд хүртээмжтэй бус; төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулаагүй	Төлөвлөгөө байгаа гэдгийг мэднэ, төлөвлөгөөг үзэх өргөн боломжтой; сургалт хийхээр төлөвлөсөн байгаа	Төлөвлөгөөг нийтлүүлэн, үндэсний түвшинд өргөн цар хүрээтэйгээр тараасан; сургалт хийх шатандаа явж байгаа	Төлөвлөгөөг нийтлүүлэн, бусад салбар, хамтран ажиллагч талууд, орон нутгийн түвшин, олон нийтэд өргөн цар хүрээтэйгээр тараасан.

Академич П.Нямдаваа, ТҮТ

8

ЧАДАВХИ 1. Үндэсний төлөвлөгөө - 3

ЧАДАВХИ 1.3.	Түвшин			
	0	1	2	Хангалттай
(С) ҮЗҮҮЛЭХ СУРГУУЛЬ, ДАСГАЛ	Төлөвлөгөөг сорьж үзээгүй эсвэл сорьж үзэх бэлтгэл хангагдаагүй	Төлөвлөгөөг сорьж үзэхээр бэлтгэж байна	Ширээний дасгал хийх замаар төлөвлөгөөний тодорхой хэсгийг сорьж үзсэн.	Ширээний дасгалын үр дүн дээр тулгуурлан төлөвлөгөөний сул талыг сайжруулах замаар төлөвлөгөөг сорьж үзсэн.

Академич П.Нямдаваа, ТҮТ

9

ЧАДАВХИ 1. Үндэсний төлөвлөгөө - 4

ЧАДАВХИ 1.4.А.	Түвшин			
	0	1	2	Хангалттай
ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ, НӨӨЦ : А	Шийдвэр гаргах бүтэц байхгүй.	Шийдвэр гаргах бүтэц үндэсний түвшинд байгуулсан.	Шийдвэр гаргах үндэсний бүтэц нь олон салбарыг хамарсан, зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааны стандарт аргачлалаа боловсруулсан.	Шийдвэр гаргах үндэсний бүтэц нь ДЭМБ болон НДББ-ийн бусад улс орнуудтай харилцан уялдаатай ажилладаг.

Академич П.Нямдаваа, ТҮТ

10

ЧАДАВХИ 1. Үндэсний төлөвлөгөө - 5

ЧАДАВХИ 1.4.Б.	Түвшин			
	0	1	2	Хангалттай
	0	1	2	3
ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ, НӨӨЦ : Б	Үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлэх нөөц байхгүй.	Үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн нөөцийг төсөвт тусгасан.	Санхүүгийн нөөцийг тухайн үеийн хэрэгцээ шаардлага болон цартахлын үе шатаас хамааран тодорхойлдог.	Үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн нөөцийн тогтвортой байдлыг хангах механизмтай

Академич П.Нямдаваа, ТҮТ

11

ЧАДАВХИ 1. Үндэсний төлөвлөгөө - 6

№	Чадавхи	Оноо
1.1.	Төлөвлөгөөний байдал	2
1.2.	Тестинг	2
1.3.	Төлөвлөгөөг түгээсэн, хэрэгжүүлсэн байдал	2
1.4.	А. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх чадавхи (хүн хүч)	1
	Б. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх чадавхи (санхүү)	1
	Дундаж	1.6

Академич П.Нямдаваа, ТҮТ

12

ЧАДАВХИ 2.

Судалгаа шинжилгээ, түүний үр дүнг ашиглаж буй байдал -1

ЧАДАВХИ 2.1.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(А) ХҮН, МАЛ АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА	Хүн ба мал, амьтны эрүүл мэндийн салбар хамтран ажилладаггүй эсвэл хязгаарлагдмал хэмжээнд хамтран ажилладаг.	Хүний эрүүл мэндийн салбарын хуралдаан дээр мал, амьтны эрүүл мэндийн асуудлыг авч хэлэлцдэг	Томуугийн цартахлын бэлэн байдлыг хангах үүрэгтэй салбар дундын, эрдэм шинжилгээний үндэсний баг байгуулагдсан бөгөөд өнгөрсөн 12 сарын хугацаанд дор хаяж нэг удаа хуралдсан.	Томуугийн цартахлын бэлэн байдлыг хангах үүрэгтэй салбар дундын, эрдэм шинжилгээний үндэсний баг зөвлөмж, бодлого боловсруулан гаргаж, эрдэм шинжилгээний бүтээлээ харилцан солилцож, мэдээллээ хуваалцдаг.

Академич П.Нямдаваа, ТҮТ

13

ЧАДАВХИ 2.

Судалгаа шинжилгээ, түүний үр дүнг ашиглаж буй байдал-2

ЧАДАВХИ 2.2.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(В) СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД	Судалгаа, шинжилгээний тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлоогүй эсвэл хязгаарлагдмал хүрээнд тодорхойлсон.	Судалгаа, шинжилгээний тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлсон.	Судалгаа шинжилгээний тэргүүлэгч үйл ажиллагааг дор хаяж хэсэгчлэн хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй.	Судалгаа шинжилгээний тэргүүлэгч үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулсан бага ч гэсэн санхүүжилт бий.

Академич П.Нямдаваа, ТҮТ

14

ЧАДАВХИ 2.

Судалгаа шинжилгээ, түүний үр дүнг ашиглаж буй байдал-3

ЧАДАВХИ 2.3.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(С) СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭХЭД ГАДААД ОРЧНООС ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ	Судалгаа шинжилгээний холбогдолтой мэдээ, мэдээллийг харилцан солилцдоггүй эсвэл хязгаарлагдмал хүрээнд солилцдог.	Судлаачид дотоодын болон гададын солилцооны хөтөлбөрт хамрагддаг.	Томуугийн үндэсний хөтөлбөр, судалгаа шинжилгээ, стратеги боловсруулах үйл явцад засгийн газар идэвхтэй оролцдог.	Судалгаа шинжилгээний тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааг боловсруулахад шаардлагатай санхүүгийн нөөцийг засгийн газраас олгодог.

Академич П.Нямдаваа, ТҮТ

15

ЧАДАВХИ 2.

Судалгаа шинжилгээ, түүний үр дүнг ашиглаж буй байдал-4

ЧАДАВХИ 2.4.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(D) МЭДЭЭ БАРИМТЫГ АШИГЛАН ТОМУУГИЙН ЦАРТАХЛЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ШИЙДВЭР ГАРГАГЧДЫГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ НЬ	Мэдээ баримт болон судалгаа шинжилгээний үр дүнг ашигладаггүй эсвэл хязгаарлагдмал хүрээнд ашигладаг	Чухал мэдээ баримтыг шийдвэр гаргагч болон бодлого төлөвлөгч нарт мэдээлдэг механизм бүрэлдсэн.	Мэдээ баримт болон судалгаа шинжилгээн дээр тулгуурлан сүүлийн 12 сарын хугацаанд дор хаяж 1 үр дүн / үйл ажиллагаа гарсан.	Сүүлийн 12 сарын хугацаанд дор хаяж 3 үр дүн гарсан, тэдгээрийн дотор бүсийн хэмжээний мэдээ баримт болон судалгаа шинжилгээн дээр тулгуурласан дор хаяж 1 үр дүн гарсан.

Академич П.Нямдаваа, ТҮТ

16

ЧАДАВХИ 2.

Судалгаа шинжилгээ, түүний үр дүнг ашиглаж буй байдал-5

No	Чадавхи	Оноо
2.1	Хүн, мал эмнэлгийн албадын хамтын ажиллагаа	1
2.2	Судалгаа шинжилгээний тэргүүлэх чиглэл	1
2.3	Судалгаа шинжилгээний үр дүнг практикт нэвтрүүлэхийг дэмжих орчин	1
2.4	ЦТББ хангах шийдвэр гаргагсад судалгаа шинжилгээний үр дүнг ашигладаг байдал	1
	Дундаж	1.0

ЧАДАВХИ 3.

Мэдээлэл, сурталчилгаа-1

ЧАДАВХИ 3.1.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(А) ХАРИЛЦАА ХОЛБООГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ	Харилцаа холбооны төлөвлөгөө байхгүй эсвэл бүрэн гүйцэд бус.	Харилцаа холбооны төлөвлөгөө томуугийн цартахлын бүх үе шатыг бус, зарим үе шатыг хамарсан.	Харилцаа холбооны төлөвлөгөө томуугийн цартахлын бүх үе шатыг хамарсан.	Цартахлын өмнөх үе шатанд хэрэгжүүлэх харилцаа холбооны төлөвлөгөөг хэрэгжүүлдэг үе үе сорьдог.

ЧАДАВХИ 3. Мэдээлэл, сурталчилгаа-2

ЧАДАВХИ 3.2.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(В) МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛ АЛТ	Мэдээлэл боловсруулаагүй эсвэл агуулга нь тодорхойгүй; хэнд зориулан мэдээлэл боловсруулахаа тогтоогоогүй.	Харилцаа холбооны материалуудыг томуугийн цартахлын үе шат бүрт тохируулан боловсруулсан.	Харилцаа холбооны материалыг зорилтот бүлгүүдэд зориулан монгол хэл дээр боловсруулсан.	Харилцаа холбооны материалыг сорьж үзсэн.

ЧАДАВХИ 3. Мэдээлэл, сурталчилгаа-3

ЧАДАВХИ 3.3.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(С) ТҮГЭЭЛТ / ТАРААЛТ	Харилцаа холбооны албан болон албан бус сувгуудыг тодорхойлоогүй эсвэл хязгаарлагдмал хүрээнд хэрэглэдэг.	Харилцаа холбооны албан болон албан бус сувгуудаа тодорхойлон, одоо ашиглаж байгаа эсвэл үндэсний түвшинд сорьж үзсэн.	Харилцаа холбооны албан болон албан бус сувгуудаа тодорхойлон, одоо ашиглаж байгаа эсвэл бүсний түвшинд сорьж үзсэн.	Харилцаа холбооны албан болон албан бус сувгууд хэвийн ажиллаж байгаа, сорилт болон хэрэглээний явцад тулгуурлан үйл ажиллагааг нь сайжруулж байдаг.

ЧАДАВХИ 3. Мэдээлэл, сурталчилгаа-4

ЧАДАВХИ 3.4.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(D) ХҮН ХҮЧИН	Олон нийттэй харилцах үүрэг бүхий албан тушаалтан, үндэсний түвшний ажилтнууд томилогдон ажилладаг.	Олон нийттэй харилцах үүрэг бүхий албан тушаалтан, үндэсний түвшний ажилтнууд томилогдон, сургалтанд хамрагдсан.	Олон нийттэй харилцах үүрэг бүхий албан тушаалтан, үндэсний дэд түвшний ажилтнууд томилогдон, сургалтанд хамрагдсан.	Олон нийттэй харилцах үүрэг бүхий албан тушаалтан, үндэсний түвшний ажилтнууд үзүүлэл сургууллт, дэгдэлтийн хариу арга хэмжээнд оролцдог.

Академич П.Нямдаваа, ТҮТ

21

ЧАДАВХИ 3. Мэдээлэл, сурталчилгаа-5

№	Чадавхи	Оноо
3.1	Мэдээлэл, сурталчилгааны төлөвлөгөө, хэрэгжилт	2
3.2	Мэдээлэл, сурталчилгааны материал	3
3.3	Түгээлт	2
3.4	Хүн хүч	2
	Дундаж	2.25

Академич П.Нямдаваа, ТҮТ

22

ЧАДАВХИ 4. Эпидемиологийн чадавхи-1

ЧАДАВХИ 4.1.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(А) ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	Төлөвлөлт, бэлтгэл байхгүй, эсвэл хязгарлагд мал хүрээнд.	Хүн амын эрүүл мэнд, гэнэтийн осол эндэгдлийг үндэсний түвшинд байнга хянах, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажиллах хүчин, нооц хангалттай бий.	Хүн амын эрүүл мэнд, гэнэтийн осол эндэгдлийг бүсийн түвшинд байнга хянах, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажиллах хүчин, нооц хангалттай бий.	Хүн амын эрүүл мэнд, гэнэтийн осол эндэгдлийг орон нутгийн түвшинд байнга хянах, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажиллах хүчин, нооц хангалттай бий.

Академич П.Нямдаваа, ТҮТ

23

ЧАДАВХИ 4. Эпидемиологийн чадавхи-2

ЧАДАВХИ 4.2.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(В) ЭПИДЕМИОЛО- ГИЧИД, ХАВСРАЛ ЭПИДЕМИОЛО- ГИЧИД	Нэг сая хүн ам тутамд нийгмийн эрүүл мэндийн практикт ажиллаж буй эпидемиологич 1 ба түүнээс бага ногдоно.	Нэг сая хүн ам тутамд нийгмийн эрүүл мэндийн практикт ажиллаж буй эпидемиологич 1 ба түүнээс олон ногдоно.	Нэг сая хүн ам тутамд нийгмийн эрүүл мэндийн практикт ажиллаж буй эпидемиологич 3 ба түүнээс олон ногдоно, нийт аймгуудын 75%-д нийгмийн эрүүл мэндийн практикт ажиллаж буй эпидемиологич 1 ба түүнээс олон ногдоно.	Нэг сая хүн ам тутамд нийгмийн эрүүл мэндийн практикт ажиллаж буй эпидемиологич 10 ба түүнээс олон ногдоно, мэргэжлээрээ ажиллаагүй байгаа эпидемиологич 25 хүртэл хувийг эзэлнэ.

Академич П.Нямдаваа, ТҮТ

24

ЧАДАВХИ 4. Эпидемиологийн чадавхи-3

ЧАДАВХИ 4.3.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(C) ХАВСРАЛ ЭПИДЕМИОЛО -ГИЧДЫН ЧАНАР	Нийгмийн эрүүл мэндийн эпидемиологичдын мэргэжлийн ур чадварыг тодорхойлоогүй эсвэл хязгаарлагдмал хүрээнд авч хэлэлцдэг.	Нийгмийн эрүүл мэндийн эпидемиологичдийн мэргэжлийн ур чадварыг тусгайлан үнэлдэг ба/буюу эпидемиологичийн ажил үүргийн стандарт боловсруулагдсан.	Практикт ажиллаж буй эпидемиологичдын мэргэжлийн ур чадварыг үнэлдэг тогтсон журам бий.	Нийгмийн эрүүл мэндийн эпидемиологичдын нэрс, мэргэжлийн чадавхийн жагсаалт гарган зарладаг.

ЧАДАВХИ 4. Эпидемиологийн чадавхи-4

ЧАДАВХИ 4.4.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(D) СУРГАЛТ	Эпидемиологийн сургалт явагдаггүй эсвэл хязгаарлагдмал хүрээнд болдог.	Өөр орны эпидемиологийн сургалтад хамрагддаг эсвэл өөрийн оронд энэ төрлийн сургалт зохион байгуулах бэлтгэлийг хангаж байгаа, эсвэл бусад хөтөлбөрийн хүрээнд зохиогддог албан бус зарим сургалт байдаг хэдий ч тэр нь үндэсний хэмжээний хэрэгцээ шаардлагыг хангадаггүй.	Эпидемиологийн сургалтын хөтөлбөр бий, сургалтын үргэлжлэх хугацаа нэг жилээс богино, үндэсний хэмжээний хэрэгцээ шаардлагыг зарим талаараа хангадаг.	Хавсрал эпидемиологи болон түүнтэй адилтгах сургалтын хөтөлбөртэй бөгөөд жил бүр тодорхой тооны мэргэжилтнийг сургаж төгсгөдөг, магадлан итгэмжлэгдсэн, үндэсний хэмжээний хэрэгцээ шаардлагыг хангасан.

ЧАДАВХИ 4. Эпидемиологийн чадавхи-5

№	Чадавхи	Оноо
4.1	Үйл ажиллагааны түвшин	0
4.2	Эпидемиологчдын хүрэлцээ	2
4.3	Эпидемиологчдын ур чадвар	1
4.4	Сургалт	2
	Дундаж	1.25

ЧАДАВХИ 5. Лабораторийн чадавхи-1

ЧАДАВХИ 5.1.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(А) ТОМУУГИЙН ЛАБОРАТОРИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ	Томуугийн оношлогоо/шинжилгээний лаборатори байгуулахаар төлөвлөөгүй эсвэл төлөвлөлт нь хязгаарлагдмал хүрээг хамарсан.	Томуугийн оношлогоо/шинжилгээний үндэсний лабораторитой.	Үндэсний лаборатори нь бүсийн хэмжээнд ажилладаг 1 ба түүнээс дээш тооны лабораторийг өөртөө багтаасан бөгөөд тэдгээрийн сорьцыг шинжлэх, баталгаажуулах үйл ажиллагаа явуулдаг.	Үндэсний лаборатори нь шинжилгээнийхээ харцуг бүсийн лабораториуддаа тогтмол эргэн мэдээлдэг тогтолцоо бүрэлдсэн.

ЧАДАВХИ 5. Лабораторийн чадавхи-2

ЧАДАВХИ 5.2.	Түвшин			
	0	1	2	Хангалттай
	0	1	2	3
(В) БИОАЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА (БАА)-НЫ ТҮВШИН, СОРЬЦЫГ БАЙНГА ШИНЖЛЭХ ҮЙЛ ЯВЦ	Томуугийн оношлогоо/шинжилгээний лаборатори байгуулахаар төлөвлөөгүй эсвэл төлөвлөлт нь хязгаарлагдмал хүрээг хамарсан.	Үндэсний лаборатори нь БАА II зэрэглэлтэй бөгөөд томуугийн шинжилгээг тогтмол хийдэггүй.	Үндэсний лаборатори нь БАА II зэрэглэлтэй бөгөөд томуугийн шинжилгээг тогтмол хийж, ДЭМБ-ын Гадаад Чанарын Хяналтын Төсөлд оролцдог.	Үндэсний лаборатори нь БААIII зэрэглэлтэй бөгөөд шувууны томуугийн вирусийг ялгах чадвартай.

ЧАДАВХИ 5. Лабораторийн чадавхи-3

ЧАДАВХИ 5.3.	Түвшин			
	0	1	2	Хангалттай
	0	1	2	3
(С) АРГАЧЛАЛ	Түргэвчилсэн оношлуур ашиглан томуугийн вирусийг ялган тодорхойлдог.	Молекул биологийн технологийг ашиглан улирлаг томуугийн вирус, вирусийн хүрээ, дэд хүрээг ялган дүйдэг, томуугийн шинэ төрлийн вирусийг ялган тодорхойлдог.	Цус наалдахыг саатуулах урвал ашиглан улирлаг томуугийн вирус, вирусийн хүрээ, дэд хүрээг ялган тодорхойлдог.	Томуугийн вирусийн эсрэгтөрөгч болон генетикийн шинж төрхийг бүрэн тодорхойлдог, БААIII зэрэглэлд томуугийн шинэ төрлийн вирусийг ялган авдаг.

ЧАДАВХИ 5. Лабораторийн чадавхи-4

ЧАДАВХИ 5.4.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(D) ДЭМБ-ЫН СҮЛЖЭЭНД ОРОЛЦДОГ БАЙДАЛ	ДЭМБ-д мэдээлдэггүй эсвэл хязгаарлагдмал хэмжээтэйгээр мэдээлдэг; ОУЭМД-ийн шаардлагад нийцүүлэн мэдээлэх бэлтгэл хангагдаагүй.	Томуугийн Үндэсний Төвийн ажил үүргийн хуваарийг мөрдөх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг, ДЭМБ руу сорьц илгээн, ДЭМБ-д байнга мэдээлж байдаг.	Томуугийн Үндэсний Төв байгуулагдсан, Flunet-ээр дамжуулан мэдээгээ тогтмол өгдөг, улирлаг болон шувууны томуугийн сорьцыг байнга солилцдог.	Олон улсын ач холбогдол бүхий нийгмийн эрүүл мэндийн онц ноцтой байдлыг ДЭМБ-д мэдээлж лабораториор баталгаажуулснаас хойш, 48 цагийн дотор сорьцыг ДЭМБ руу илгээдэг,

Академич П.Нямдаваа, ТҮТ

31

ЧАДАВХИ 5. Лабораторийн чадавхи-5

№	Чадавхи	Оноо
5.1	Томуугийн лабораторийн тандалтын үндэсний сүлжээ	1
5.2	Био-аюулгүй ажиллагааны түвшин, сорьц боловсруулалтын түвшин	2
5.3	Хэрэглэж буй арга	2
5.4	ДЭМБ-ын Томуугийн тандалтын сүлжээнд оролцдог байдал	2
	Дундаж	1.75

Академич П.Нямдаваа, ТҮТ

32

ЧАДАВХИ 6. Томуугийн байнгын тандалт-1

ЧАДАВХИ 6.1.	Түвшин			
	0	1	2	Хангалттай
	0	1	2	3
(А) ВИРУСОЛОГИЙН БОЛОН ЭПИДЕМИОЛОГИЙН ТАНДАЛТЫН УЯЛДАА ХОЛБОО	Эмнэлэгт тохиолдох амьсгалын замын халтай, цочмог халдварыг тандах харуулдан тандалтын тогтолцоо бүрэлдээгүй.	Эмнэлэгт тохиолдох амьсгалын замын халтай, цочмог халдвар болон ТТӨ-ий вирусологийн мэдээ баримтыг цуглуулдаг харуулдан тандалтын цэг дор хаяж 1 бий.	Эмнэлэгт тохиолдох амьсгалын замын халтай, цочмог халдвар болон ТТӨ-ий вирусологи болон эпидемиологийн мэдээ баримтыг цуглуулдаг харуулдан тандалтын цэг дор хаяж 1 бий.	Эмнэлэгт тохиолдох амьсгалын замын халтай халдварыг газарзүйн тархалтыг төлөөлөхүйцээр сонгон авсан харуулдан тандалтын олон цэг бий.

Академич П.Нямдаваа, ТҮТ

33

ЧАДАВХИ 6. Томуугийн байнгын тандалт-2

ЧАДАВХИ 6.2.	Түвшин			
	0	1	2	Хангалттай
	0	1	2	3
(В) МЭДЭЭ БАРИМТЫГ НИЙТЛҮҮЛЭХ БАЙДАЛ	Мэдээ мэдээллийг жилд хоёр хүртэл удаа хэвлэн нийтлүүлдэг эсвэл тараадаг.	Мэдээ мэдээллийг жилд дор хаяж хоёр удаа хэвлэн нийтлүүлдэг эсвэл тараадаг.	Мэдээ мэдээллийг жилд дор хаяж хоёр удаа хэвлэн нийтлүүлдэг, гэхдээ энэ нь томуугийн улирлын туршид долоо хоногоос урт хугацааны давтамжтай байдаг.	Томуугийн улирлын туршид мэдээ мэдээллийг долоо хоног тутам хэвлэн нийтлүүлдэг эсвэл тараадаг.

Академич П.Нямдаваа, ТҮТ

34

ЧАДАВХИ 6.
Томуугийн байнгын тандалт-3

ЧАДАВХИ 6.3.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(С) ЦАГ ХУГАЦААНДАА МЭДЭЭЛДЭГ БАЙДАЛ	Тогтоосон хугацааны 20 хүртэл хувьд нь багтаан мэдээ мэдээллийг хүлээн авч, дүн шинжилгээ хийн, холбогдох талуудад хүргүүлдэг.	Тогтоосон хугацааны 20 - 50 хувьд нь багтаан мэдээ мэдээллийг хүлээн авч, дүн шинжилгээ хийн, холбогдох талуудад хүргүүлдэг.	Тогтоосон хугацааны 51-80 хувьд нь багтаан мэдээ мэдээллийг хүлээн авч, дүн шинжилгээ хийн, холбогдох талуудад хүргүүлдэг.	Тогтоосон хугацааны 80-иас доошгүй хувьд нь багтаан мэдээ мэдээллийг хүлээн авч, дүн шинжилгээ хийн, холбогдох талуудад хүргүүлдэг.

Академич П.Нямдаваа, ТҮТ

35

ЧАДАВХИ 6.
Томуугийн байнгын тандалт-4

ЧАДАВХИ 6.4.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(D) ТОХИОЛДЛЫН ТОДОРХОЙЛОЛ ТУУД	Тохиолдлын тодорхойлолт байхгүй эсвэл бүрэн боловсруулсангүй.	Тохиолдлын тодорхойлолтын төслийг боловсруулсан байгаа.	Тохиолдлын тодорхойлолтыг шинэчилсэн боловч ДЭМБ-аас боловсруулсан тохиолдлын тодорхойлолт биш.	ДЭМБ-аас боловсруулсан тохиолдлын стандарт тодорхойлолтыг хэрэглэсэн.

Академич П.Нямдаваа, ТҮТ

36

ЧАДАВХИ 6. Томуугийн байнгын тандалт-5

№	Чадавхи	Оноо
6.1	Вирүс судлалын болон эпидемиологийн тандалтын уялдаа	2
6.2	Эргэх мэдээллийн түвшин	3
6.3	Мэдээллийн шуурхай байдал	2
6.4	Эмнэлзүйн тандалтанд хэрэглэдэг тодорхойлолт	3
	Дундаж	2.50

ЧАДАВХИ 7. ТТӨ-ний үндэсний тандалт, мэдээлэл-1

ЧАДАВХИ 7.1.	Түвшин			Хангалттай
	0	1	2	
(А) ӨВЧНИЙ ТАЛААРХ ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭХ БАЙДАЛ	Эрүүл мэндийн ажилтнууд болон олон нийтийг сургадаггүй, эсвэл сургах оролдлого хязгаарлагд мал.	Эрүүл мэндийн ажилтныг сургах кампанит ажил хэрэгждэг хэдий ч тэр нь дутуу дулимаг; нийгмийн эрүүл мэндийн зарим мэдээллийг зорилтот бүлгийн хүн амд зориулан олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээдэг.	Эрүүл мэндийн ажилтан болон олон нийтэд зориулсан өвчний талаарх мэдээлэл хүргэх кампанит ажлын цар хүрээ өргөжин тэлж байгаа.	Олон нийтэд зориулсан өвчний талаарх мэдээллүүд нь мэдээллийн олон хэлбэрээр дамжин үндэсний хэмжээнд түгэн тардаг; нийт хүн ам болон эрүүл мэндийн ажилтнуудад мэдээлэл түгээх механизм хэвийн ажиллаж байгаа, тогтвортой байдлыг хангах механизм бүрэлдсэн.

ЧАДАВХИ 7.

ТТӨ-ний үндэсний тандалт, мэдээлэл-2

САРАВИЛГҮ 7.2.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(В) АМ ДАМЖСАН ЯРИА, ЦУУРХЛЫГ МЭДЭЭЛЭХ ҮЙЛ ЯВЦ	Албан бус мэдээллийн эх үүсвэрийг хянах тогтолцоо байхгүй эсвэл хязгаарлагдмал хүрээнд ажиглагддаг.	Албан бус мэдээллийн эх үүсвэрийг хянах тогтолцоо үндэсний түвшинд бүрэлдсэн, бүртгэл хөтөлгдөг.	Албан бус мэдээллийн эх үүсвэрийг хянах тогтолцоо үндэсний дэд түвшинд бүрэлдсэн, бүртгэл хөтөлгдөг; түвшин хооронд байнгын харилцаа холбоотой, болзошгүй аюулын дор хаяж 1 түгшүүрийг сар тутам шинжлэн судалдаг.	Хариу арга хэмжээний бүртгэлийг үндэсний болон үндэсний дэд түвшинд бүрэн хөтөлдөг; болзошгүй аюулын дор хаяж 2 түгшүүрийг сар тутам шинжлэн судалдаг.

Академич П.Нямдаваа, ТҮТ

39

ЧАДАВХИ 7.

ТТӨ-ний үндэсний тандалт, мэдээлэл-3

САРАВИЛГҮ 7.3.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(С) САЛБАР ДУНДЫН ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ	Эрүүл мэнд болон хөдөө аж ахуйн яамдууд хоорондоо харилцан мэдээлдэггүй, эсвэл хязгаарлагдмал хүрээнд мэдээлдэг.	Эрүүл мэнд болон хөдөө аж ахуйн яамдууд хоорондоо харилцан мэдээлдэг хэдий ч тэр нь зарим үед хоцрох үзэгдэл төхиолдоно, харилцаа холбооны механизм нь системчлэгдээгүй.	Эрүүл мэнд болон хөдөө аж ахуйн яамдууд хоорондоо цаг алдалгүй харилцан мэдээлдэг системслэгдсэн механизм үндэсний түвшинд бүрэлдсэн.	Үйл явдлыг хамтран судлан шинжилдэг.

Академич П.Нямдаваа, ТҮТ

40

ЧАДАВХИ 7.

ТТӨ-ний үндэсний тандалт, мэдээлэл-4

CAPABILITY 7.4.	Түвшин			Хангалттай
	0	1	2	
(D) ЦАГ ХУГАЦААНДАА МЭДЭЭЛСЭН БАЙДАЛ	Амьсгалын халдварын дэгдэлт, голомтот халдварын багаахан хэсгийг өвчин гарснаас хойш 48 цагийн дотор мэдээлсэн (few).	Амьсгалын халдварын дэгдэлт, голомтот халдварын тодорхой хэсгийг өвчин гарснаас хойш 48 цагийн дотор мэдээлсэн (some).	Амьсгалын халдварын дэгдэлт, голомтот халдварын ихэнх хэсгийг өвчин гарснаас хойш 48 цагийн дотор мэдээлсэн (many).	Амьсгалын халдварын дэгдэлт, голомтот халдварын дийлэнх хэсгийг өвчин гарснаас хойш 48 цагийн дотор мэдээлсэн (most).

ЧАДАВХИ 7.

ТТӨ-ний үндэсний тандалт, мэдээлэл-5

No	Capability	Score
7.1	Мэдээлэл, сурталчилгааны хамралт	2
7.2	Албан бус мэдээлэлд хандах байдал	0
7.3	Салбар хоорондын мэдээлэл солилцоо	1
7.4	Мэдээллийн шуурхай байдал	2
	Дундаж	1.25

ЧАДАВХИ 8.

Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ-1

ЧАДАВХИ 8.1.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(А) ДЭГДЭЛТИЙН ҮЕИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ ХАРИУЦСАН ХҮН ХҮЧНИЙ НӨӨЦ	Дэгдэлтийн хариу арга хэмжээ хариуцсан баг байхгүй.	ДЭМБ-ын шуурхай хариу арга хэмжээний сургалтанд хамрагдан, энэ чиглэлээр бэлтгэгдсэн хүмүүсээс бүрдсэн 1-ээс дээш тооны баг үндэсний түвшинд ажилладаг.	ДЭМБ-ын шуурхай хариу арга хэмжээний сургалтанд хамрагдан, энэ чиглэлээр бэлтгэгдсэн хүмүүсээс бүрдсэн 1-ээс дээш тооны баг үндэсний дэд түвшинд ажилладаг.	ДЭМБ-ын шуурхай хариу арга хэмжээний сургалтанд хамрагдан, энэ чиглэлээр бэлтгэгдсэн хүмүүсээс бүрдсэн 1-ээс дээш тооны баг үндэсний дэд түвшин бүрд ажилладаг, тогтвортой байдлыг хангах механизм бүрэлдсэн.

Академич П.Нямдаваа, ТҮТ

43

ЧАДАВХИ 8.

Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ-2

ЧАДАВХИ 8.2.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(В) ДЭГДЭЛТИЙН ҮЕИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНД ЗОРИУЛСАН ЭД МАТЕРИАЛЫН НӨӨЦ	Шинэ төрлийн тэмүү овчгийг судлан шинжлэх, түүний эсрэг хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж байхгүй эсвэл хязгар, тэгдмэл.	Тоног төхөөрөмж байгаа бөгөөд хариу арга хэмжээг үндэсний түвшинд хэрэгжүүлэх 1 хүртлэх тооны баг зэрэг ашиглах боломжтой.	Тоног төхөөрөмж байгаа бөгөөд хариу арга хэмжээг үндэсний дэд түвшинд хэрэгжүүлэх 1 хүртлэх тооны баг зэрэг ашиглах боломжтой.	Тоног төхөөрөмж байгаа бөгөөд хариу арга хэмжээг үндэсний дэд түвшин бүрд хэрэгжүүлэх 1-ээс дээш тооны баг зэрэг ашиглах боломжтой.

Академич П.Нямдаваа, ТҮТ

44

ЧАДАВХИ 8.

Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ-3

ЧАДАВХИ 8.3.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(С) ДАСГАЛ СУРГУУЛИЛТ БОЛОН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ	Дэгдэлт болон үзүүлэх сургуулилтанд тэр бүр хариу арга хэмжээ аваад байдаггүй.	Жилд дор хаяж нэг удаа нэгээс дээш тооны баг үндэсний түвшинд дасгал сургуулилт явуулж, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.	Жилд дор хаяж нэг удаа нэгээс дээш тооны баг үндэсний дэд түвшинд дасгал сургуулилт явуулж, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.	Жилд дор хаяж нэг удаа нэгээс дээш тооны баг үндэсний дэд түвшин бүрд дасгал сургуулилт явуулж, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлдэг; төв байгууллага ерөнхийд нь зохицуулдаг.

ЧАДАВХИ 8.

Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ-4

ЧАДАВХИ 8.4.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(D) БАГИЙГ ИДЭВХЖҮҮ ЛЭХ	Хариу арга хэмжээ бүрэн зохион байгуулагдаагүй/тоноглогдоогүй, эсвэл нийгмийн эрүүл мэндийн онц ноцтой байдал мэдээлэгдсэнээс хойш баг 4 хоногийн дотор газар дээр нь очдог.	Сургагдаж бэлтгэгдэн, холбогдох багаж төхөөрөмжөөр бүрэн хангагдсан баг 3 хоногийн дотор газар дээр нь очно.	Сургагдаж бэлтгэгдэн, холбогдох багаж төхөөрөмжөөр бүрэн хангагдсан баг 2 хоногийн дотор газар дээр нь очно.	Сургагдаж бэлтгэгдэн, холбогдох багаж төхөөрөмжөөр бүрэн хангагдсан баг 1 хоногийн дотор газар дээр нь очиж, лабораторийн сорьцыг 24 цагийн дотор, шинжилгээний хариуг 72 цагийн дотор тус тус илгээнэ.

ЧАДАВХИ 8.

Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ-5

№	Чадавхи	Оноо
8.1	Хүн хүчний нөөц	1
8.2	Материаллаг нөөц	0
8.3	Дасгал сургууль	1
8.4	Хариу арга хэмжээний багийн шуурхай байдал	2
	Дундаж	1.00

ЧАДАВХИ 9.

Дэгдэлтийг хязгаарлах нөөц-1

ЧАДАВХИ 9.1.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(А) ВИРУСИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭЛТЭЙ ЭМ БЭЛДМЭЛ	Вирусийн эсрэг үйлдэлтэй эм бэлдмэлийг үндэсний хэмжээнд нөөцлөөгүй эсвэл хязгаарлагд мал нөөцтэй.	Вирусийн эсрэг үйлдэлтэй эм бэлдмэлийн нөөц нь 1 200 хүний 20 хоногийн хэрэгцээг хангана.	Вирусийн эсрэг үйлдэлтэй эм бэлдмэлийн нөөц нь 12 000 хүний 20 хоногийн хэрэгцээг хангана.	Вирусийн эсрэг үйлдэлтэй эм бэлдмэлийн нөөц нь 100 000 хүний 20 хоногийн хэрэгцээг хангана.

ЧАДАВХИ 9. Дэгдэлтийг хязгаарлах нөөц-2

ЧАДАВХИ 9.2.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(В) ХАДГАЛАХ БАГТААМЖ	Вирусийн эсрэг үйлдэлтэй эм бэлдмэлийг хадгалах улсын агуулах байхгүй.	Улсын агуулах байдаг боловч эмийн бэлдмэл хадгалах зориулалтгүй, харуул хамгаалалт, хэмийн хяналт, багаж хэрэгслийн бүртгэл зарцуулалт, нөөцийн эргэлт нь хангалтгүй.	Харуул хамгаалалт, хэмийн хяналт, багаж хэрэгслийн бүртгэл зарцуулалт, нөөцийн эргэлт нь шаардлага хангасан улсын агуулах бий.	Эм хадгалах эрхийн зөвшөөрөл бүхий байгууллагатай засгийн газар албан ёсны гэрээ байгуулсан.

ЧАДАВХИ 9. Дэгдэлтийг хязгаарлах нөөц-3

ЧАДАВХИ 9.3.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(С) ДАСГАЛ СУРГУУЛИЛТ	Сүүлийн 12 сарын хугацаанд дасгал сургуулилт хийгдээгүй.	Сүүлийн 12 сарын хугацаанд ширээний дасгал эсвэл түүнтэй адилтгахуйц дасгал сургуулилт хийгдсэн.	Сүүлийн 12 сарын хугацаанд үзүүлэх сургуулилт хийгдсэн.	Энэ чиглэлээрх үйл ажиллагаа тогтмолжсоныг илтгэх баримт нотолгоо.

ЧАДАВХИ 9.
Дэгдэлтийг хязгаарлах нөөц-4

ЧАДАВХИ 9.4.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(D) МАТЕРИАЛЫГ ТҮГЭЭХ / ТАРААХ	Хязгаарлалттай холбоотой материалыг 24 цагийн дотор нутаг дэвсгэрийн 25 хүртээх хувьд тарааж чадна.	Хязгаарлалттай холбоотой материалыг 24 цагийн дотор нутаг дэвсгэрийн 25-49%-д тарааж чадна.	Хязгаарлалттай холбоотой материалыг 24 цагийн дотор нутаг дэвсгэрийн 50-74%-д тарааж чадна.	Хязгаарлалттай холбоотой материалыг 24 цагийн дотор нутаг дэвсгэрийн 75-аас дээш хувьд тарааж чадна.

ЧАДАВХИ 9.
Дэгдэлтийг хязгаарлах нөөц-5

№	Чадавхи	Оноо
9.1	Вирүсийн эсрэг бэлдмэлийн нөөц	0
9.2	Эм хадгалах чадавхи	1
9.3	Дасгал, сургууль	0
9.4	Түгээх чадавхи	0
	Дундаж	0.25

ЧАДАВХИ 10.

Олон нийтэд тулгуурласан арга хэмжээ-1

ЧАДАВХИ 10.1.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(А) НИЙГМИЙН ХОРИО	Төлөвлөлт, бэлтгэл байхгүй эсвэл дутуу.	Сургууль цэцэрлэг, албан байгууллагыг хаах/дахин нээх, олон нийтийн цуглааныг хориглох чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө, зарим нэг дүрэм заавар бий.	Сургууль цэцэрлэг, албан байгууллагыг хаах/дахин нээх, олон нийтийн цуглааныг хориглох талаар нарийвчлан тусгасан заавар/ төлөвлөгөө байгаа бөгөөд энэ нь цартахлын хүндрэлийн зэргээс хамааралтайгаар боловсруулагдсан болно.	Цартахлын хүндрэлийн зэргээс хамааралтайгаар боловсруулагдсан заавар журмыг сургууль цэцэрлэг, албан байгууллага, олон нийтэд хүртээмжтэйгээр тараасан.

Академич П.Нямдаваа, ТҮТ

53

ЧАДАВХИ 10.

Олон нийтэд тулгуурласан арга хэмжээ-2

ЧАДАВХИ 10.2.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(В) ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ДЭД БҮТЭЦ	Төлөвлөлт, бэлтгэл байхгүй эсвэл дутуу.	Зайлшгүй шаардлагатай дэд бүтцийн хэвийн үйл ажиллагааг хангах төлөвлөгөө, заавар журам бий.	Зайлшгүй шаардлагатай дэд бүтцийн хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр нарийвчлан тусгасан төлөвлөгөө, заавар журам бий бөгөөд энэ нь цартахлын хүндрэлийн зэргээс хамааралтайгаар боловсруулагдсан болно.	Цартахлын хүндрэлийн зэргээс хамааралтайгаар боловсруулагдсан заавар журмыг сургууль цэцэрлэг, албан байгууллага, олон нийтэд хүртээмжтэйгээр тараасан.

Академич П.Нямдаваа, ТҮТ

54

ЧАДАВХИ 10.

Олон нийтэд тулгуурласан арга хэмжээ-3

ЧАДАВХИ 10.3.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(С) САЙН ДУРЫН ТУСГААРЛАЛТ, ХӨЛ ХОРИО	Төлөвлөлт, бэлтгэл байхгүй эсвэл дутуу.	Сайн дурын тусгаарла лт, хөл хорионы чиглэлээр гаргасан зөвлөмж бий.	Сайн дурын тусгаарлалт, хөл хорионы чиглэлээр хуримтлуулсан туршлагыг вирусийн эсрэг үйлдэлтэй эм бэлдмэлийн эмчилгээ, сэргийлэлттэй цуг хавсран хэрэглэдэг.	Тусгаарлалт, хөл хориог эрт үед авч хэрэгжүүлдэг бөгөөд олон нийт энэ төрлийн арга хэмжээг хүлээн зөвшөөрдөг.

ЧАДАВХИ 10.

Олон нийтэд тулгуурласан арга хэмжээ-4

ЧАДАВХИ 10.4.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(D) ӨӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ТЭЙ ДУУРГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ	Төлөвлөлт, бэлтгэл хангалт	Нийт дүүргийн 5% нь олон нийтийг дайчлах өөрийн гэсэн бичмэл төлөвлөгөөтэй.	Нийт дүүргийн 5- 25% нь олон нийтийг дайчлах өөрийн гэсэн бичмэл төлөвлөгөөтэй.	Нийт дүүргийн 25-аас дээш хувь нь олон нийтийг дайчлах өөрийн гэсэн бичмэл төлөвлөгөөтэй.

ЧАДАВХИ 10.

Олон нийтэд тулгуурласан арга хэмжээ-5

№	Чадавхи	Оноо
10.1	Хөл хөдөлгөөнийг багасгах	2
10.2	Нийтийн үйлчилгээг тасалдуулахгүй байх	0
10.3	Сайн дурын тусгаарлалт, хөл хорио	1
10.4	Төлөвлөлтийн түвшин	3
	Дундаж	1.50

ЧАДАВХИ 11.

Халдвар хамгаалал-1

ЧАДАВХИ 11.1.	Түвшин			
	0	1	2	Хангалттай
(А) ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦООНЫ ТҮВШИН БҮР ДЭХ ХАЛДВАР ХАМГААЛЛЫН СТАНДАРТ ДЭГЛЭМ	Халдвар хамгааллын дэглэмийн төслийг хэлэлцээгүй эсвэл хязгаарлагдмал хурээнд хэлэлцсэн.	Шинэ болон сэжигтэй омгийн халдвартай харьцаж ажиллах үүрэг бүхий эрүүл мэндийн төв байгууллагад дагаж мөрддөг халдвар хамгааллын стандарт бий, тэрхүү стандарт нь ДЭМБ-ын стандартад нийцсэн эсвэл түүнээс давсан.	Эрүүл мэндийн тогтолцооны түвшин бүрд халдвар хамгааллын стандарт байдаг бөгөөд түүний чанарыг хянах тогтолцоо ч мөн бүрэлдсэн.	Чанарыг хяналтыг хэрэгжүүлэгч тогтолцоонд бүх түвшин хамрагддаг.

ЧАДАВХИ 11. Халдвар хамгаалал-2

ЧАДАВХИ 11.2.	Түвшин			
	0	1	2	Хангалттай
	0	1	2	3
(В) ХҮНИЙ НӨӨЦ	Халдвар хамгааллын стандарт бүрийг хэрэгжүүлэх сургалт явагддаггүй эсвэл хязгаарлагдмал хүрээнд болдог.	Халдварын хяналтын чиглэлээр сургагдаж бэлтгэгдсэн боловсон хүчин төвийн/нутаг дэвсгэрийн бүх эмнэлгүүдэд бий.	Халдварын хяналтын чиглэлээр сургагдаж бэлтгэгдсэн боловсон хүчин ихэнх (>80%) аймгийн эмнэлгүүдэд бий.	Аймгийн эмнэлгүүдээс гадна ихэнх (>80%) дүүргийн эмнэлгүүдэд мэргэшсэн ажилтан бий.

ЧАДАВХИ 11. Халдвар хамгаалал-3

ЧАДАВХИ 11.3.	Түвшин			
	0	1	2	Хангалттай
	0	1	2	3
(С) ЭД МАТЕРИАЛЫН НӨӨЦ	Халдвар хамгааллын чиглэлээрх материал байхгүй эсвэл ховор, төв эмнэлгүүдэд тоног төхөөрөмж тэр бүр хүртээмжтэй байдаггүй.	Төвийн эмнэлгүүдэд байдаг халдвар хамгааллын чиглэлээрх материалууд нь халдвар хамгааллын үндэсний стандартын шаардлагыг хангадаг.	Дүүргийн эмнэлгүүдэд байдаг халдвар хамгааллын чиглэлээрх материалууд нь ДЭМБ-ын халдвар хамгааллын стандартын шаардлагыг хангадаг.	Халдвар хамгааллын чиглэлээрх материалуудыг дүргийн эмнэлэг хүртэлх түвшинд түгээх чадавхтай бөгөөд айл өрх болон бүсийн түвшинд мөрддөг стандарт нь ДЭМБ-ын халдвар хамгааллын стандартын шаардлагыг хангадаг.

ЧАДАВХИ 11. Халдвар хамгаалал-4

ЧАДАВХИ 11.4.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(D) ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БАЙГУУЛЛАГЫ Н ХЭМЖЭЭНД МӨРДӨХ	Халдвар хамгааллын асуудлыг төрийн болон хувийн салбарт авч хэлэлцдэггүй.	ЭМЯ-нд халдвар хамгааллын асуудал хариуцсан нэгж байдаг.	Халдвар хамгааллын асуудал хариуцсан зөвлөл бүсийн, аймгийн, эмнэлгийн түвшинд ажиллаж, мэдээ баримт цуглуулан, мэдээлдэг.	Мэргэжлийн нийгэмлэг зарчмын хувьд халдвар хамгааллын асуудлыг удирддан зохицуулдаг, халдвар хамгааллын асуудлыг сайжруулах 3 жилийн хугацаатай үндэсний төлөвлөгөө бий.

ЧАДАВХИ 11. Халдвар хамгаалал-5

№	Чадавхи	Оноо
11.1	Халдвар хамгааллын түвшин	2
11.2	Хүн хүчний нөөц	2
11.3	Материаллаг нөөц	1
11.4	Халдвар хамгааллын албаны байдал	2
	Дундаж	1.75

ЧАДАВХИ 12.

Эрүүл мэндийн салбарын бэлэн байдал-1

ЧАДАВХИ 12.1.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(А) ХҮНИЙ НӨӨЦ	Нартахлын 4-6-р шатанд осон нэмэгдэх хүн хүчний хэрэгцээг хэрхэн зохицуулахыг төлөвлөсгүй, тэр үед хэвн хүн ажиллах нь тодорхойгүй.	Осон нэмэгдэх хүн хүчний нөөцийг хэрхэн зохицуулахыг тусгасан албан ёсны төлөвлөгөө бий. Холбогдох мэдээ баримт дээр тулгуурлан одоо байгаа болон тухайн үед шаардагдах хүн хүчний тоог тодорхойлсон. Дуудагдаж ажиллах, дайчлагдан ажиллах хүмүүсийн жагсаалтыг гаргасан.	Төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсвөө тооцоолсон, хэрэгцээг тодорхойлох программ хангамж бий.	Төлөвлөгдсөн хүчин чадавхийн 50-наас дээш хувийг хангах нөөц бий. Төлөвлөгөөнд хууль эрх зүйн асуудлыг тусгасан.

Академич П.Нямдаваа, ТҮТ

63

ЧАДАВХИ 12.

Эрүүл мэндийн салбарын бэлэн байдал-2

ЧАДАВХИ 12.2А.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(В) ЭД МАТЕРИА, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИ ЙН НӨӨЦ	Эмнэлгийн орны тоо тодорхойгүй; гэрийн үйлчилгээ болон эмнэлгийн орны тоог нэмэгдүүлэх төлөвлөгөө байхгүй эсвэл хязгаарлагдмал хүрээнд төлөвлөсөн.	Гэрийн үйлчилгээ болон эмнэлгийн орны тоог нэмэгдүүлэх төлөвлөгөө байгаа бөгөөд тодорхой тоо баримт дээр үндэслэн тодорхойлсон тухайн үеийн хэрэгцээ шаардлага болон одоогийн хүчин чадавхийг тус тус төлөвлөгөөнд тусгасан.	Төлөвлөгөөг хэрэгжүүлэх болон нөөцийг зарцуулах төсвийг тодорхойлсон; хэрэгцээг тодорхойлох программ хангамж бий.	Төлөвлөгдсөн хүчин чадавхийн 50-наас дээш хувийг хангах нөөц бий.

Академич П.Нямдаваа, ТҮТ

64

ЧАДАВХИ 12.

Эрүүл мэндийн салбарын бэлэн байдал-3

ЧАДАВХИ 12.2Б.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(В) ЭД МАТЕРИА, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИ ЙН НӨӨЦ	Агааржуулагч болон операторуудын тоо тодорхойгүй, агааржуулагч болон операторын хүчин чадлыг нэмэгдүүлэх төлөвлөгөө байхгүй эсвэл хязгаарлагдмал хүрээнд төлөвлөсөн.	Агааржуулагч болон операторын хүчин чадлыг нэмэгдүүлэх албан ёсны төлөвлөгөө байгаа бөгөөд тодорхой тоо баримт дээр үндэслэн тодорхойлсон тухайн үеийн хэрэгцээ шаардлага болон одоогийн хүчин чадавхийг тус тус төлөвлөгөөнд тусгасан.	Төлөвлөгөөг хэрэгжүүлэх болон ноогийг зарцуулах төсвийг тодорхойлсон; хэрэгцээг тодорхойлох программ хангамж бий.	Төлөвлөгдсөн хүчин чадавхийн 50-наас дээш хувийг хангах нөөц бий.

Академич П.Нямдаваа, ТҮТ

65

ЧАДАВХИ 12.

Эрүүл мэндийн салбарын бэлэн байдал-4

ЧАДАВХИ 12.3.	Түвшин			
				Хангалттай
	0	1	2	3
(С) ЭМНЭЛЗҮЙН МЕНЕЖМЕНТ	Томуугийн шинэ төрлийн вирусийн халдвартай өвчтөнийг оношлох, эмчлэх эмнэлзүйн менежементийн гарын авлага байхгүй эсвэл байгаа аргачлал нь хязгаарлагдмал хүрээг хамарсан.	Эмнэлзүйн менежементийн гарын авлага байгаа бөгөөд өргөн хүрээтэйгээр тараасан; гарын авлага нь ДЭМБ-ын шаардлагыг хангасан, эсвэл түүнээс давсан.	Эмнэлзүйн менежементийн гарын авлагын чиглэлээр үндэсний түвшинд ажилтнууд сургагдаж бэлтгэгдсэн.	Эмнэлзүйн менежементийн гарын авлагын чиглэлээр үндэсний дэд түвшинд ажилтнууд сургагдаж бэлтгэгдсэн.

Академич П.Нямдаваа, ТҮТ

66

ЧАДАВХИ 12.

Эрүүл мэндийн салбарын бэлэн байдал-5

ЧАДАВХИ 12.4.	Түвшин			
	0	1	2	Хангалттай
(D) ОРШУУЛГА	Нас барагсдын асуудлыг хэрхэн зохицуулах талаар төлөвлөөгүй, эсвэл хязгаарлагдмал хүрээнд төлөвлөсөн.	Нас барагсдын асуудлыг зохицуулах төлөвлөгөө байгаа бөгөөд тодорхой тоо баримт дээр үндэслэн тодорхойлсон тухайн үеийн хэрэгцээ шаардлага болон одоогийн хүчин чадавхийг тус тус төлөвлөгөөнд тусгасан.	Төлөвлөгөөг хэрэгжүүлэх болон ноогийг зарцуулах төсвийг тодорхойлсон; хэрэгцээг тодорхойлох программ хангамж бий.	Нас барагсдыг ялган таних, түр зуур хадгалах, заншлын дагуу оршуулах үйл ажиллагааны ноог болон төлөвлөгөө нь төлөвлөгдсөн хүчин чадавхийн 50-наас дээш хувийг хангана.

Академич П.Нямдаваа, ТҮТ

67

ЧАДАВХИ 12.

Эрүүл мэндийн салбарын бэлэн байдал-6

№	Чадавхи	Оноо
12.1	Хүн хүчний нэмэлт нөөц бүрдүүлэх	0
12.2	Материаллаг нэмэлт нөөц бүрдүүлэх	0
12.3.	Эмчилгээний удирдамж	2
12.4.	Нас барагсадын үйлчилгээний нэмэлт нөөц бүрдүүлэх	0
	Дундаж	0.50

Академич П.Нямдаваа, ТҮТ


68

- ТЦББ-ын үнэлгээний хэрэгсэл, Анхны үнэлгээ (I.A), 2008.IV
- Нөхөн үнэлгээ-(0 түвшин), 2008.XI
- Аймаг, нийслэлийг оруулсан үнэлгээ (I.B), 2009.III
- Хоёрдахь үнэлгээ, 2010.VI

2003:2008 оны харьцуулсан ҮЗҮҮЛЭЛТ-1

	2003	2008
• Үндэсний төлөвлөгөө	0.00	1.60
• Судалгаа шинжилгээ	0.25	1.00
• Мэдээлэл, сурталчилгаа	0.25	2.25
• Эпидемиологийн чадавхи	1.25	1.25
• Лабораторийн чадавхи	0.75	1.75
• Томуугийн байнгын тандалт	1.00	2.50
• ТТӨ-ний үндэсний тандалт, мэдээлэл	0.75	1.25
• Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ	0.00	1.00
• Дэгдэлтийг хязгаарлах нөөц	0.50	0.25
• Олон нийтэд тулгуурласан арга хэмжээ	0.25	1.50
• Халдвар хамгаалал	1.00	1.75
• Эрүүл мэндийн салбарын бэлэн байдал	0.00	0.50
ДУНДАЖ:	0.50	1.38

2003:2008 оны харьцуулсан үзүүлэлт-2



Академич П.Нямдаваа, ТҮТ

71

- ТЦББ-ын үнэлгээний хэрэгсэл, Анхны үнэлгээ (I.A), 2008.IV
- Нөхөн үнэлгээ (0 түвшин), 2008.XI
- Аймаг, нийслэлийг оруулсан үнэлгээ (I.B), 2009.III
- Хоёрдахь үнэлгээ, 2010.VI

Академич П.Нямдаваа, ТҮТ

72

Аймаг, нийслэлийг оруулсан үнэлгээ-1

Хамарсан хүрээ

- Үнэлгээг 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэгт хийв.

Хугацаа

- 2009 оны 3 дугаар сарын 5 -19 өдрүүдэд хийсэн.

Санхүүжилт

- Дэлхийн банкны дэмжлэгтэй хэрэгжиж буй “Шувууны томуу, хүний томуугийн цартахалтай тэмцэх чадавхыг сайжруулах” төсөл

Аймаг, нийслэлийг оруулсан үнэлгээ-2

Үнэлгээний багийн бүрэлдэхүүн

- Онцгой байдлын ерөнхий газар
- Эрүүл мэндийн яам
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
- Мал эмнэлгийн хүрээлэн
- Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори
- Халдварт өвчин судлалын үндэсний төв
- Байгалийн голомтот халдварт өвчин судлалын үндэсний төв
- “Шувууны томуу, хүний томуугийн цартахалтай тэмцэх чадавхыг сайжруулах” төслийн баг

Аймаг, нийслэлийг оруулсан үнэлгээ-3

Үнэлгээнд хамрагдсан байгууллагууд

- Аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газар
- Аймаг, нийслэл, дүүргийн Онцгой байдлын газар, хэлтэс, алба
- Аймаг, нийслэл, дүүргийн Эрүүл мэндийн газар (өрхийн эмнэлэг, БГХӨСТ)
- Клиникийн болон тусгай мэргэжлийн төв эмнэлэг
- Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг
- Дүүргийн эрүүл мэндийн нэгдэл
- Аймаг, нийслэл, дүүргийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
- Мал эмнэлэг
- Холбоо, цахилгаан сүлжээ, ус суваг, дулаан хангамжийн байгууллага
- Аймаг, нийслэл, дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэс, газар
- Аймаг, нийслэл, дүүргийн Цагдаагийн хэлтэс
- Аймаг, нийслэл, дүүргийн Байгаль орчин аялал жуулчлалын газар

Аймаг, нийслэлийг оруулсан үнэлгээ-4

Үнэлгээнд оролцогсод

- Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, орлогч,
- Тамгийн газрын дарга, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтэн,
- Онцгой байдлын газар, хэлтэс, албаны дарга, орлогч, мэргэжилтэн,
- Аймаг, дүүргийн эрүүл мэндийн газар, нэгдэл, нэгдсэн эмнэлэг
- БОЭТ-ийн дарга, орлогч, чанарын менежер, халдвар судлагч, халдвартын эмч, нян судлаач, өрх хариуцсан мэргэжилтэн, өрхийн эмнэлгийн ахлагч,

Аймаг, нийслэлийг оруулсан үнэлгээ-5

Үнэлгээнд оролцогсод

- Тухайн дүүргийн нутаг дэвсгэрт байгаа клиникийн эмнэлгүүд тухайлбал Цэргийн төв эмнэлэг, Шастины нэрэмжит нэгдсэн 3 –р эмнэлэг, Клиникийн нэгдсэн 2-р эмнэлэг, БГХӨСҮТ,
- Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар,
- Дүүргийн үйлдвэр үйлчилгээний хэлтэсийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн,
- Дүүргийн боловсролын хэлтэсийн дарга, газрын албаны мэргэжилтэн,

Аймаг, нийслэлийг оруулсан үнэлгээ-6

Үнэлгээнд оролцогсод

- Санхүү, төрийн сан хариуцсан мэргэжилтэн,
- Дулааны асуудал хариуцсан мэргэжилтэн,
- Тохижилт үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн,
- Монголын цахилгаан холбоо хариуцсан мэргэжилтэн,
- Дүүргийн замын цагдаагийн тасгийн мэргэжилтэн,
- Улаанзагалмайн хорооны мэргэжилтэн зэрэг нийт 500 гаруй хүн үнэлгээнд оролцов.

Аймаг, нийслэлийг оруулсан үнэлгээ-7

№	Чадавх	2008 он	2009 он		
		Үндэсний түвшин	Улсын дундаж	Аймгийн дундаж	Нийслэлийн дундаж
1.	Томуугийн цартахлын бэлэн байдлын төлөвлөгөө	1,6	0,77	1,2	0,35
2.	Салбар дундын хамтын ажиллагаа	2,25	1,56	1,2	1,92
3.	Аймаг, нийслэлийн гамшгийн үеийн холбоо зарлан мэдээлэл		1,8	1,5	2,1

Академич П.Нямдаваа, ТҮТ

79

Аймаг, нийслэлийг оруулсан үнэлгээ-8

№	Чадавх	2008он	2009 он		
		Үндэсний түвшин	Улсын дундаж	Аймгийн дундаж	Нийслэлийн дундаж
4.	Эпидемиологийн чадавхи	1,25	1,25	0,9	1,6
5.	Лабораторийн чадавхи	1,75	1	0,7	1,3
6.	Томуугийн байнгын тандалт	2,5	2,27	1,8	2,75

Академич П.Нямдаваа, ТҮТ

80

Аймаг, нийслэлийг оруулсан үнэлгээ-9

№	Чадавх	2008 он	2009 он		
		Үндэсний түвшин	Улсын дундаж	Аймгийн дундаж	Нийслэлийн дундаж
7.	Хүний амьсгалын замын өвчний тандалт мэдээлэл	1,25	1,94	1,7	2,18
8.	Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ	1	1,45	1,3	1,6
9.	Дэгдэлтийг хязгаарлах нөөц	0,25	0,78	0,7	0,86

Академич П.Нямдаваа, ТҮТ 81

Аймаг, нийслэлийг оруулсан үнэлгээ-10

№	Чадавх	2008 он	2009 он		
		Үндэсний түвшин	Улсын дундаж	Аймгийн дундаж	Нийслэлийн дундаж
10	Томуугийг гаргалтаас сэргийлэх олон нийтэд суурилсан арга хэмжээ	1,5	1,05	1,1	1
11	Халдвар хамгаалал	1,75	1,53	1,15	1,92
12	Эрүүл мэндийн салбарын чадавх	0,5	0,85	0,7	1

Академич П.Нямдаваа, ТҮТ 82


Аймаг, нийслэлийг оруулсан үнэлгээ-11

№	Чадавх	2008 он	2009 он		
		Үндэсний түвшин	Улсын дундаж	Аймгийн дундаж	Нийслэлийн дундаж
13	Мал эмнэлгийн салбарын чадавх	-	1,77	1,35	2,2
14	Онцгой байдлын албаны чадавх	-	1,28	1,35	1,22
15	Өрхийн эмнэлгийн чадавх	-	1,41	1,3	1,53
	Дундаж	1,45	1,38	1,19	1,56

Академич П.Нямдаваа, ТҮТ

83

Өмнөх 3 үнэлгээний харьцуулсан үзүүлэлт



Академич П.Нямдаваа, ТҮТ


84

- ТЦББ-ын үнэлгээний хэрэгсэл, Анхны үнэлгээ (I.A), 2008.IV
- Нөхөн үнэлгээ (0 түвшин), 2008.XI
- Аймаг, нийслэлийг оруулсан үнэлгээ (I.B), 2009.III
- Хоёрдахь үнэлгээ, 2010.VI

2008:2010 оны харьцуулсан үзүүлэлт-1

	2008	2010
• Үндэсний төлөвлөгөө	1.60	1.88
• Судалгаа шинжилгээ	1.00	2.00
• Мэдээлэл, сурталчилгаа	2.25	2.25
• Эпидемиологийн чадавхи	1.25	1.50
• Лабораторийн чадавхи	1.75	2.00
• Томуугийн байнгын тандалт	2.50	3.00
• ТТӨ-ний үндэсний тандалт, мэдээлэл	1.25	1.75
• Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ	1.00	1.75
• Дэгдэлтийг хязгаарлах нөөц	0.25	0.75
• Олон нийтэд тулгуурласан арга хэмжээ	1.50	2.00
• Халдвар хамгаалал	1.75	1.50
• Эрүүл мэндийн салбарын бэлэн байдал	0.50	0.80
ДУНДАЖ:	1.38	1.77

2008:2010 оны харьцуулсан үзүүлэлт-2



Академич П.Нямдаваа, ТҮТ

87

Талархал

Илтгэлийн слайдыг бэлтгэхэд тусалсан
ТҮТ-ийн вэбмастер/дата менежер
Б.Ганцоожид зохиогч талархсанаа
илэрхийлж байна

Академич П.Нямдаваа, ТҮТ

88

ТЦБ-ын үнэлгээ, 2012 оны 9 сарын 19, Улаанбаатар

Анхаарал тавьсанд баярлалаа

Академич П.Нямдаваа, ТҮТ

89